



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 06 сарын 18 өдөр

Дугаар 265

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 1,169,210,950.00 (нэг тэрбум нэг зуун жаран есөн сая хоёр зуун арван мянга есөн зуун тавин) төгрөгийн балансын үнэ бүхий цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй нь Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2015 оны 02-07-388/2063 тоот дүгнэлтээр тогтоогдсон энэ тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Сургалт, хүмүүжлийн тусгай байгууллага (хуучнаар 411 дүгээр анги) үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 382,901,458.45 (гурван зуун наян хоёр сая есөн зуун нэгэн мянга дөрвөн зуун тавин найман төгрөг дөчин таван мөнгө) төгрөгийн балансын үнэ, 341,479,581.85 (гурван зуун дөчин нэгэн сая дөрвөн зуун далан есөн мянга таван зуун наян нэгэн төгрөг наян таван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй нь Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2015 оны 02-07-388/2063 тоот дүгнэлтээр тогтоогдсон энэ тогтоолын 2 дугаар хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

3.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга Д.Дамдинцэрэн болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, буулгах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

3.2.Үл хөдлөх хөрөнгийг акталж буулгах, газар /чөлөөлөгдөх талбай/-ыг албан ажлын зориулалтаас өөрөөр ашиглахгүй байх;

3.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

0000491

3.4. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.


4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ




Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



А.АРИУНБОЛД



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 06 дугаар сарын 18 ны өдрийн
06.5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬАА 401 ДҮГЭЭР ХААЛТАЙ ХОРИХ АНГИ
НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон он	Хэм жих нэгж	Тоо хэм жээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Автограж	2002	ш	1	5,922,000.00	5,922,000.00	5,922,000.00	-
2	Машины граж	1998	ш	1	2,116,800.00	2,116,800.00	2,116,800.00	-
3	Соёлын төв	1998	ш	1	16,224,000.00	16,224,000.00	16,224,000.00	-
4	Талхны байр	1972	ш	1	3,292,800.00	3,292,800.00	3,292,800.00	-
5	Угаалга моорг	1972	ш	1	14,700,000.00	14,700,000.00	14,700,000.00	-
6	Уурын зуухны барилга	1957	ш	1	13,572,000.00	13,572,000.00	13,572,000.00	-
7	Эмнэлгийн А байр	1958	ш	1	1,045,800,000.00	1,045,800,000.00	1,045,800,000.00	-
8	Эргэлт уулзалтын хүлээлгийн байр	2002	ш	1	4,165,000.00	4,165,000.00	4,165,000.00	-
9	Шалган нэвтрүүлэх байр	2008	ш	1	14,602,000.00	14,602,000.00	14,602,000.00	-
10	Склад	2013	ш	1	4,247,350.00	4,247,350.00	4,247,350.00	-
11	Зонны 4 тал хашаа	1995	ш	1	35,112,000.00	35,112,000.00	35,112,000.00	-
12	Ногооны зоорь	1998	ш	1	1,940,400.00	1,940,400.00	1,940,400.00	-
13	Харуулын 1-р постын цамхаг	2003	ш	1	1,411,200.00	1,411,200.00	1,411,200.00	-
14	Харуулын амрах байр	1999	ш	1	1,842,400.00	1,842,400.00	1,842,400.00	-
15	Харуулын цамхаг	1996	ш	1	4,263,000.00	4,263,000.00	4,263,000.00	-
	Нийт дүн					1,169,210,950.00	1,169,210,950.00	

6090159 - 1118252883

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн
265 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬАА СУРГАЛТ, ХҮМҮҮЖЛИЙН ТУСГАЙ
БАЙГУУЛЛАГА (хуучнаар хорих 411 дүгээр анги)-ЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛЭЙ,
АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

6098169 1118262983

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон он	Хэм жих нэгж	Тоо хэм жээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Хэрмэн хашаа	2007	ш	1	35,721,000.00	35,721,000.00	21,907,200.00	13,813,800.00
2	Сургалтын төв	2002	ш	1	50,274,300.00	50,274,300.00	22,666,223.40	27,608,076.60
3	Мужаан цех	1997	ш	1	5,355,000.00	5,355,000.00	5,355,000.00	-
4	Талхан цех	1997	ш	1	1,701,000.00	1,701,000.00	1,701,000.00	-
5	Төв байр	1955	ш	1	279,615,008.00	279,615,008.00	279,615,008.00	-
6	Гүний худаг	1997	ш	1	1,297,800.00	1,297,800.00	1,297,800.00	-
7	Мөсөн зоорь	1997	ш	1	1,231,650.45	1,231,650.45	1,231,650.45	-
8	Аж ахуйн склад	1996	ш	1	3,163,400.00	3,163,400.00	3,163,400.00	-
9	Хүлэмж	2002	ш	1	3,395,700.00	3,395,700.00	3,395,700.00	-
10	Жижжүүрийн байр	1997	ш	1	1,146,600.00	1,146,600.00	1,146,600.00	-
	Нийт дүн					382,901,458.45	341,479,581.85	41,421,876.60